



ХЭНТИЙ АЙМГИЙН
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 23 өдөр

Дугаар 5/20

Өмнөдэлгэр сум

Үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 40 дүгээр зүйлийн 40.3, 40.4.2 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4 дэх заалт, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 1.2. 1.2.1, 2.1, 2.2, 2.3 дахь заалт, Засгийн газрын 2023 оны 442 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймаг, сумын Засаг даргын захирамж, мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг чанартай зохион байгуулж ажилласан Засаг даргын орлогч, багийн Засаг дарга нар болон Засаг даргын Тамгын газрын 2025 оны хагас жилийн гүйцэтгэлийн үнэлгээ, ажлын үр дүнг үндэслэн Засаг даргын Тамгын газрын дарга Л.Баярмаад цалингийн урамшуулал олгосугай.


2. Урамшуулал олгох албан хаагчдын нэрс, урамшууллын хувийг хавсралтаар баталсугай.

3. Урамшууллыг үндсэн цалингаас бодож, Засаг даргын Тамгын газрын цалингийн сангаас олгохыг нягтлан бодогч (Б.Гантулга)-д зөвшөөрсүгэй.



Р.ЭНХТӨР

сумын Засаг даргын 2025 оны
16 дугаар сарын 23-ны өдрийн
5/20 дугаар захирамжийн хавсралт



Албан хаагчдын нэрс, урамшуулал олгох хувь

№	Овог нэр	Албан тушаал	Урамшуулал олгох хувь
1	Л.Баярмаа	Засаг даргын Тамгын газрын дарга	50
2	Б.Оюунгэрэл	Засаг даргын орлогч	50
2	Д.Наранчимэг	Наран, 1-р багийн Засаг дарга	50
3	Г.Эрдэнэсүвд	Баянзүрх, 2-р багийн Засаг дарга	50
4	А.Баянмөнх	Хэнтий, 3-р багийн Засаг дарга	40
5	М.Сод-Ирээдүй	Талын булаг, 4-р багийн Засаг дарга	40
6	Э.Заяабаяр	Чандган, 5-р багийн Засаг дарга	40
7	Б.Хонгорзул	Төв, 6-р багийн Засаг дарга	50
8	Ж.Энххуяг	Гурванбаян, 7-р багийн Засаг дарга	50